

СУРГАН ХҮМҮҮЖҮҮЛЭГЧ СЭХЭЭТЭН, ТҮҮНИЙ НИЙГМИЙН ҮҮРЭГ

Э.Тамир

МУБИС-ийн Түүх нийгмийн ухааны сургууль

Summary

The changes in today's society challenges the social role of mongolian teacher's and educators. This is multifaceted, complicated and dialectic process. The paper is defining the current status of the mongolian teacher and educator and it's new roles.

Түлхүүр үг:

Боловсролын системийн үечлэл (1921-1942; 1942-1980; 1980- хойш); диалектик; зайлшгүй чанар; иргэншил, нийгмийн үүрэг; СХС тухайлсан харилцаа;

Судлаачид сэхээтнийг янз бүрийн түвшинд цар хүрээгээр олон янз байдлаас өөр өөрсдийн арга барилаар судлан, дүгнэж ирсэн байна.

Сэхээтэн /латины intelligens/ ухаантай, ойлгодог, мэддэг, мэдлэгтэй, мэргэжилтэн гэсэн үг/ - оюуны хөдөлмөрийг мэргэжин эрхэлдэг хүмүүсийг нэгтгэсэн нийгмийн давхраа юм. “Сэхээтэн” хэмээх нэр томъёог анх 19-р зууны 60-аад оны үед оросын зохиолч П.Д.Боборыкин хэрэглээнд оруулжээ. Анхандаа “сэхээтэн” гэдэгт тэргүүний үзэл санаа бүхий соёл, боловсролтой хүмүүсийг тэмдэглэж байснаа улмаар тодорхой хөдөлмөр, тодорхой мэргэшлийн хүмүүст хамааруулж үзэх болсон байна.

Ф.Энгельс сэхээтэнд холбогдох асуудлыг түүхэн хандлага, аргаар авч үзэхдээ “... Дан ганц биеийн хөдөлмөр эрхлэгч асар олонхын зэрэгцээгээр шууд үйлдвэрлэлийн хөдөлмөрөөс чөлөөлөгдсөн бөгөөд нийгмийн үйл хэрэг; төр, засаг, шүүхийг удирдах, шинжлэх ухаан, урлаг эрхлэх ажил явуулдаг бүлэг бий болсон байна гэж бичжээ. Энэ тодорхойлолтоос үзэхэд сэхээтэн бол нийгмийн түүхэн үзэгдэл бөгөөд хүн төрөлхтөний хөгжлийн тодорхой үе шатанд буй болж, өсч хөгжиж төлөвших явцдаа нийгэмд эзлэх байр суурь, гүйцэтгэх үүрэг нь харилцан адилгүй байсан нь Монголын нийгмийн амьдралаар тодорхойлогдож байна.

Монгол хэлний үгийн санд “сэхээтэн” гэдэг нэр томъёо 30-аад жилийн өмнө оржээ. Хувьсгалаас хойш 30-аад жил сэхээтэн гэдэг ойлголтыг “оюутан” хэмээх нэр томъёогоор илэрхийлж ирсэн байна.

1960-аад оны үндсэн хуульд анх Сэхээтэн хэмээн томъёологдож нам төрийн баримт бичгүүд, утга зохиолын хэлнээ хэрэглэгдэх болов.

Нийгмийн бүтцийн үүднээс сэхээтнийг нийгмийн давхраа хэмээн үзвээс сэхээтэн нь өргөн утгаараа мэдлэгийг бүтээгч, хүмүүжүүлэгч, хөгжүүлэгч хүч мөн.

Ингэхлээр сэхээтнийг нийгмийн шинжлэх ухааны категори, судлагдахуун гэж үзвэл энэ нь үнэхээр нарийн төвөгтэй, олон талтай ойлголт төдийгүй нэг талаас багш сэхээтний үүсэл хөгжил нь улс орны эдийн засаг, улс төр, социал болон оюуны салбарын ололт, амжилтаар нөхцөлдөж, нөгөө талаар тэдний үйл ажиллагаа нь нийгмийн амьдралын бүх хүрээг өөрчлөн хөгжүүлэх чухал хүчин зүйл болж ирсэн байна.

Судлаачид монголын сэхээтний үүсэл, хөгжлийн явцыг судлахдаа түүний үечлэлд нилээд анхаарал хандуулж, нам, төрийн гол, гол баримт бичгүүдэд ардын хувьсгалын үе шатны талаар тэмдэглэж ирсэн үечлэлийг үндэс суурь болгон авч үзжээ. Жишээ нь: Б.Балдоо, Ц.Готов нарын бүтээлд манай сэхээтний үүсэл хөгжлийг 3 үе болгож үзээд, 1921-1940 оныг нэгдүгээр, 1940-1960

оныг хоёрдугаар, 1960-1990 оныг гуравдугаар үе гэж тус тус ангилсан байна. Б.Лигүүгийн “БНМАУ-д ардын сэхээтэн үүссэн нь, нийгмийн бүтцэнд түүний эзлэх байр суурь” /УБ. 1983/ хэмээх номд Монгол улсад сэхээтэн бүрэлдэн тогтсон үйл явцыг 1921-1940, 1940-одоо/1983/ хүртэлх үе гэж ангилсан байна. “Өнөөгийн сэхээтний нийгмийн төрх” УБ. 1987, “БНМАУ-ын соёлын түүх” УБ. 1981. Хэмээх бүтээлүүдэд сэхээтний төлөвшил, хөгжлийн үе шатыг соёлын хувьсгалын үе шаттай холбож, 1921-1940, 1940-1960, 1960-аас хойшхи үе гэж ангилсан байна

Дээрхи үечлэлүүд нь хэдийгээр тухайн үеийн баримт материалын судалгаанд тулгуурласан боловч анхаарч үзүүштэй учир дутагдалтай юм. Учир нь хуучин догматик баримтлалаар Монголд 1940 он гэхэд ардчилсан, 1960 онд социалист шатны зорилт бүрмөсөн биелж, 1960 оноос хойш Монгол нь социализм бүрэн ялсан орон байх ёстой байв. Үнэн хэрэгтээ нь онолын эндүүрэл, практикийн алдаа; Социализмын Сталинч маягийн хувилбарыг үнэн бодотой социализм мэтээр дүрслэн харуулж улмаар улс, хоршооллын өмчийн хоёр хэлбэрийг тогтоосноор социализмын ялалт хангагдана гэж үзэж байсантай холбоотой юм.

Нийгмийн аливаа өөрчлөгдөн хөгжигч объектын нэгэн адил сэхээтний өсөлт, хөгжилт нь нарийн төвөгтэй диалектик үйл явц мөн.

Шинэчлэлтийн байр сууринаас хандахад сэхээтний давхраа үүсч тогтсон нь маргаангүй баримт боловч социалист сэхээтэн бус харин сэхээтнийг ардын, хөдөлмөрийн сэхээтэн гэж нэрлэх инь илүү оновчтой байж болох талаас нь үзвэл Монголын сэхээтний үүсэл тогтнол, өсөлт хөгжлийн үйл явцыг 1921-1980-аад он, түүнээс хойших үе гэж ангилах нь үнэн байдалд нийцнэ гэж үзэж байна. Нэгдэх үе бол 1921-1980-аад оны үед хуучин сэхээтнийг өвлөн авч зохистой ашиглахаасаа хэлмэгдүүлэх явдал нь ихэдсэн нь харамсалтай байна. Энэ үед залуучуудыг гол төлөв хөвгүүдийг гадаад оронд, юуны урд ЗХУ-д явуулж суралцуулах, дотооддоо ерөнхий боловсролын дунд тусгай мэргэжлийн дунд сургууль, курсээр бэлтгэх аргаар сэхээтний давхрааг төрүүлжээ.

Эхний үед сэхээтний эгнээнд түүх, хэл бичиг, утга зохиол, түмэн бодис, газар зүйн багш нар голлож байсан нь аль нэг талаар үндэсний түүхэн уламжлалтай холбоотой нөгөө талаар нийгмийн тухайн үеийн эрэлт хэрэгцээгээр нөхцөлдөж байжээ.

Хоёрдахь үе шатны онцлог нь эдийн засаг, соёлын бараг бүх салбарын шаардлагатай тусгай, дунд, дээд боловсролтой боловсон хүчнийг эх орондоо бэлтгэх бололцоотой болсон; үүнтэй уялдан сэхээтэн, багш нарын эгнээ мэргэжлийн төрөл, бүтэц, тоо ба чанарын талаар өсч бэхжсэн тэдний гадаад хэлний бэлтгэл эрс өсч нэмэгдсэн улс орны гадаад харилцаа өргөжин тэлсэн; мэдээлэл холбоо, харилцааны хэрэгсэл харьцангуй их хөгжсөн; хүн амын өсөлт, дотоодын шилжин байршилт, суурьшил, төвлөрөл, хөгжилт ихэссэн; энэ бүхний үндсэн дээр оршино Сэхээтэн - багш нарын улс төрийн соёл ухамсар нийгмийн идэвхи байнга дээшилж ирсэнд оршино.

Сэхээтнийг эзэмшсэн мэргэжил, эрхэлж буй ажлын төрөл, онцлогоор нь ангилж үзвээс **багшлах сурган хүмүүжүүлэх мэргэжил эзэмшсэн, өсвөрийн болон залуу үеийг сурган хүмүүжүүлэх ажил эрхэлдэг мэргэжилтнүүдийг сурган хүмүүжүүлэгч сэхээтэн гэдэг.** Өөрөө нийгмийн сэхээтэн хэмээх давхраа болон төлөвшөөд сэхээтнийг төрүүлдэг нь багш сурган хүмүүжүүлэгчдийн гол онцлог шинж юм.

Хэрэв сэхээтнийг бүхэллэг систем гэж үзвэл сурган хүмүүжүүлэгчид буюу багш сэхээтэн нь бүхлийн хэсэг юм. Ингэхлээр бүхлийн төлөвшилийн үе шаттай, хэсгийн төлөвшил тохирох нь зайлшгүй. Гэхдээ бас давхцахгүй ч ёс бий. Жишээ нь: Монголын ард түмэн өнө эртний хөгжил, түүх, соёлтой. Гэтэл ард түмний салшгүй хэсэг болсон сэхээтэн саяхан төлөвшин тогтсоныг өгүүлсэн. Бас сэхээтэн бүхлийн хувьд төлөвшчихөөд байхад нилээд хожим инженер — техникийн сэхээтэн төлөвшсөн нь няцаалтгүй баримт юм.

(СХС) сурган хүмүүжүүлэгч сэхээтний төлөвшлийн үе шат өвөрмөц онцлогтой байж болох байр сууринаас үзвээс (СХС)-ний төлөвшлийн үе шатыг боловсролын нийт тогтолцооны үүсэл, хөгжлийн үе шаттай холбож үзэх нь зүйтэй. Үүнд: СХС-ний төлөвшил, хөгжлийн нэг дэх үе нь 1921 оноос 1942 оныг хамрана. Энэ үе шатанд дээр ерөнхий боловсролын систем үндсэндээ бүрэлдэн тогтож их сургууль байгуулагджээ. СХС-ний хоёрдугаар үе нь дээд боловсролын систем үүсэн тогтсон 1942-1980аад оны үеийг хамрах юм. Гуравдугаар үе нь: 1980-аад оны дунд үеэс хойшхи үеийг хамрана. СХС төлөвшлийнхөө нэг дэх шатанд курсын, бүрэн бус, боловсролтой хүмүүсээс бүрдэл болж байлаа. Хоёр дахь үе шатны онцлог нь дээд боловсролын системийн сурган хүмүүжүүлэгчдийн бүлэг үүсэж бага, дунд шатны иудын багш нарын мэргэжил дээшлүүлэх систем буй болж үйлчлэх болжээ. Үүний бага, дунд шатны сургуулийн багш сурган - хүмүүжүүлэгчийн боловсрол, мэргэжил цуцалтгүй дээшилж ирсэн байна. Гурав дахь үе шатны нэг онцлог нь сурган хүмүүжүүлэгчдийн ол, мэргэжлийг эрс дээшлүүлэх сэтгэлгээ, сурган хүмүүжүүлэх арга барил, ур чадварыг бараг үндсээр нь өөрчлөх шаардлагатай болсноор тодорхойлогдож байна. Энэ нь нийгмийн өөрчлөлт — шинэчлэлтээр нөхцөлдөж буй юм.

Хэдийгээр СХС нь аль ч улс оронд сэхээтэн бүрэлдэн тогтох түгээмэл зүй тогтлын дагуу н тогтож, төлөвшин хөгжиж ирсэн боловч өөрийн гэсэн өвөрмөц жам хуулиар үүсч, өсч, иж ирсэн байна. Энэ нь багш сэхээтний эрхэлдэг үйл ажиллагааны салбарын онцлогоор тодорхойлогдож байна.

СХС-ний гол үйл ажиллагаа бол оюуны хөдөлмөр мөн болох нь тодорхой билээ. Гэхдээ энэ нь ихээхэн онцлогтой юм. Хэрэв эрдэм шинжилгээний ажилтан сэхээтэн амьгүй, амьтай байгаль, хүнтэй шууд ба дам холбоотой тодорхой объектыг дан ганц өөрийнхөө хувийн оюун ухаан, авъяас чадвараараа судлан боловсруулдаг бол СХС нийгмийн ухаантай амьтан болсон суралцагчидтай ажилладаг. Хэрэв аль ч эрдэм шинжилгээний ажилтанд сэтгэлийн хөдөлгөөн, өдөр дутмын туршилт төдий л шаардагддаггүй бол СХС хүний үйл ажиллагаанд үзэл суртал ба сэтгэл зүй, оюун ухааны зарцуулалт ба туршилтын нэгдэл асар их шаардагддаг. Ингэхлээр СХС-ний үйл ажиллагаа нь нэг талаар түүний хувийнх нь мэргэжлийн боловсрол, хүнийг сурган хүмүүжүүлэх ур чадвар, дадлага туршлага, нөгөө талаас бие бялдар, оюун ухаан, мэдлэг нь өсөн хөгжиж байдаг суралцагчдын оюуны үйл ажилгааны нэгдэл болон илэрч байдаг. Онол ба практик; ам ба ажлын нэгдлийг өдөр тутамд байнга хангаж байх нь СХ-ийн үйл ажиллагааны нэг онцлог юм. Энэ бүхнээс үзэхэд СХ-ийн үүссэн тогтнол төлөвшил хөгжлийн өвөрмөц объектив зүй тогтол урган гарч байна.

Энэ нь нэгдүгээрт, ардын багшийн зохих бэлтгэлгүй байхад ардын боловсролын систем шинээр үүсч, бэхжиж, хөгжиж ирсэн; хоёрдугаарт, боловсролын систем үүсч хөгжихийн хэрээр СХС өөрөө өсч, боловсорч хөгжиж ирсэн; гуравдугаарт, СХС-ний мэргэжил, сурган хүмүүжүүлэх ур чадварын өсөлт нийгмийн идэвхи соёл түүний дотор улс төрийн соёлынх нь төлөвлөөс боловсролын системийн бэхжилт, хөгжилт, ялангуяа өсвөрийн болон залуу үеийнхний сурлага, хүмүүжил, ажлын амжилт бүх талаар хамаарч ирсэн; дөрөвдүгээрт, залуу хойч үеийн боловсролоос улс орны одоо ирээдүй хамаарах болсоноор илэрч буй билээ.

Улс орны өөрчлөлт, хөгжлийг аль ч үе шатанд хангахад чиглэгдсэн ямарч нарийн төвөгтэй зорилтыг шийдвэрлэх чадвар бүхий бие хүнийг сурган хүмүүжүүлж, төлөвшүүлэх нь схийн мэргэжлийн үндсэн зорилго, иргэний гол үүрэг мөн. Энэ нь сурган хүмүүжүүлэгчдийн бүхий л үйл ажиллагаа хүүхэд, залуучуудын зөв иргэншил, иргэний нийгмийн идэвхитэй үйл ажиллагааг төлөвшүүлэхэд шууд ба дам чиглэгдэж байдгийг харуулж байна. СХ-ийн энэхүү зорилго, үүрэг хэрхэн биелж, ямар үр дүнд хүрэх нь түүний боловсрол, мэргэжил, сургах хүмүүжүүлэх ур чадвараас тодорхой хэмжээгээр шалтгаалдаг.

Олон улсын хийгээд үндэсний уламжлалыг харгалзан “номын багш” хэмээх СХ-ийн үүргийг үндсэн хоёр төрөл буюу түвшин; 1-рт, залуу үе болон ахмад үеийн залгамж холбоог бэхжүүлж хөгжүүлэх; 2-рт, төрөл бүрийн шинжлэх ухааны мэдлэг мэргэжилд сургах зөв иргэншүүлж, хүмүүжүүлэх үүргийг авч үзье.

Ахмад ба залуу үеийн хоорондын холбоо, харилцаа, харилцан хамаарал нийгмийн түүхэн хөгжлөөр нөхцөлддөг. Аль ч нийгмийн улс үндэстний ахмад үе үр хүүхэд, ач зээ, гуч дөч нараа сурган хүмүүжүүлж, хойч үеэ бэлтгэдэг, мэдлэг дадлага, эд өлгийн хийгээд оюуныхаа соёлын үнэт зүйлийг өвлүүлж өгдөг хойч үе нь түүнийг нандигнан хамгаалж, аривжуулан хөгжүүлж байдаг нь хүн төрлөхтний дэвшлийн түгээмэл жам ёс юм.

Нийгмийн дэвшлийн хөгжлийн явцад нэг талаар натурал аж ахуй саад учруулах нөгөө талаар шинжлэх ухаан, нийгмийн туршлага цар хэмжээгээрээ өргөн шинж чанараараа олон янз болсноос гэр бүлийн хүрээнд боловсрол эзэмших бололцоо хунигджээ. Нийгмийн хөгжил, дэвшлийн явцад үйлдвэрлэл сургалт улам бүр нийгмийн шинжтэй болж. Хүүхэд, залуучуудад боловсрол эзэмшүүлэхгүйгээр нийгмийн дэвшлийг хангах явдал хязгаар төрөгсөд нь ажил дээрээ байдаг хүүхэд, залуучууд нь ихэвчлэн улс. " хүүхдийн ясли, цэцэрлэгт хүмүүждэг, бүх шатны

сургуульд сурдаг/-д хүмүүжиж, сурдаг олсон орчин үеийн нөхцөлд гэр бүлийн хүрээнд ахмад ба залуу үеийн хоорондын тухайлсан харилцаа сулрах хандлага илэрч байна. Сүүлийн үед орон нутагт сургуулийн хүүхэд завсардаж эцэг, эхийнхээ аж ахуйн үйл ажиллагаанд тусладаг, оролцдог болсноор ахмад ба залуу үеийн хоорондын харилцааны хуучин хэв маягийн зарим шинж сэрэл нийгмийг бүхэлд нь хамарч чадсангүй. Энэ талаар анхаарч үзүүштэй хэд хэдэн хүчин зүйл байна. Үүнд: нэг, иргэдийн аж төрөх ёс, сэтгэл зүй, үзэл санаа өнгөрсөн тодорхой хугацаанд асар их өөрчлөгдлөө; хоёрт, хотжих, хотууд томсох явцад хүн амын бөөгнөрөл, суурьшил эрчимжиж байна; гуравт, анхдагч хамт олон найз нөхдийн хүрээний болон төр, засаг, улс төрийн нам, эвсэл, холбоод, олон нийтийн байгууллага, хэвлэл, радио, телевиз болон олон нийтийн шинжтэй мэдээлэл, нөлөөлөлийн хэрэгслэлүүдийн үүрэг өсч нэмэгдсээр байна.

Энэ нь ахмад ба залуу үеийн хоорондын харилцааны шинэ төрлүүд буй болсныг харуулж байна. Энэ нь чухамдаа орчин үеийн нийгмийн хөгжил, дэвшлийн онцлогоор нөхцөлдөж байна.

Мэдлэг, боловсролын харьцангуй өндөр төвшин нь орчин үеийн залуучуудад амьдрал, хөдөлмөрийнхөө асуудлыг биеэ дааж шийдвэрлэх улмаар ахмад хүмүүсээс чөлөөтэй, тусгаар байх бололцоо олгож байна. Ф.Энгельс чөлөөт байдлыг “... ажил хэргийн мэдлэгтэйгээр шийдвэр гаргах арга чадвар чөлөөт байдлыг танигдаж мэдэгдсэн зайлшгүй чанар мөн” гэж үзжээ. Ийм утгаар чөлөөт байдал нь танигдаж мэдэгдсэн зайлшгүй чанар мөн.

Орчин үе залуу хүмүүст бүтээлч авъяас чадвараа чөлөөтэй хөгжүүлэх, нийгмийн амьдралд ухамсар, идэвхитэй оролцох бололцоо олгож байгаа нь түүний дэвшлийн зайлшгүй чухал нөхцөл юм. Учир нь нийгмийн үйлчлэл, хөгжлийн хуулиудын объектив, субъектив талуудын диалектик нэгдэл ухамсартай хангагдаж байж нийгэм хөгжиж дэвшдэг. Залуучууд чөлөөтэй, ухамсартай үйл ажиллагааны үр дүнд нийгмийн амьдралд гүнзгий орж хувь заяаныхаа асуудлыг өөрийнхөө болон нийгмийн ашиг тусад нийцүүлэн шийдвэрлэж чаддаг улмаар нийгмийн хөгжлийн хуулийн объектив, субъектив талуудын диалектик нэгдэл хангагдаж байдаг байна. Ухамсартай идэвхи шинийг эрэлхийлэх, амьдралд чин сэтгэлээсээ хандах хандлага зэрэг нь соёл иргэншлийн өнөөгийн шаардлага, хэрэгцээгээр нөхцөлдөж залуучуудын иргэншлийн онцлог төрх болж байна. Ахмадуудаас залуучуудын чөлөөтэй, тусгаар байдал нь биеэ даасан шинжийн хэлбэрээр илэрч байна.

Хүний мэдлэг, боловсролын өндөр түвшин; нийгмийн амьдралд эзлэх байр суурь; гүйцэтгэх үүргээ гүнзгий ухамсарлах чадвар бол түүний ухамсартай, чөлөөтэй үйл ажиллагааны чухал нөхцөл

юм. Нөгөө талаар энэ бүхэн нь нэг талаар хүний өөрийгөө хянах дотоод оюун ухааны үндэс суурь нөгөө талаар уг хяналтын үйл ажиллагаа, зан авираар дамжин илэрч байдаг гадаад илрэл юм.

Орчин үеийн залуучууд ахмад үеийнхнийг бодвол өөрийгөө болон бусад хүмүүсийг илүү эрчимтэй таниж мэддэг болжээ. Хүний өөрийгөө таниж мэдэх үйл явц нарийн төвөгтэй юм. Хүнийг таньж мэдэхийн тулд амьдралын туршлагатай байх үүний тулд бусдыг болон өөрийгөө таньж мэдэх хэрэгтэй болдог байна. Нийгмийн гишүүд иргэний адил тэгш эрхтэй боловч амьдралын асуудлаа адил тэгш шийдвэрлэх адилхан бололцоо байдаггүй, байж ч чадахгүй. Иймээс хүн өөрийгөө сайтар таниж мэдсэний үндсэн дээр амьдралын асуудлаа зөв шийдвэрлэх гол баталгаа нь мэдлэг, боловсрол эзэмших явдал мөн. Ялангуяа улс орон зах зээлийн эдийн засагт шилжиж буй оноо үед мэдлэг боловсролын зохих төвшингүйгээр залуучууд сайн сайхан амьдрах тухай ярих нь огт бүтэшгүй хэрэг болно.

Хүн амын насны бүлгүүдийн харилцааны асуудал нь тэдгээрийн залгамж холбоо, ялгааны харилцааны асуудалд хамаарагдана. Бидний бодлоор ахмад ба залуу үеийнхний залгамж холбоо, ялгааг диалектик үгүйсгэлийн үзлийн үүднээс тайлбарлах бололцоотой бөгөөд ийм тайлбар нийгмийн үзэгдлүүдийн онцлогийг тусгадаг.

Диалектик үгүйсгэл бол хуучин үеэ өнгөрөөснийг зөвхөн үгүйсгэх биш өнгөрсөн үе шатуудад буй болсон дэвшилтэй, үнэ цэнэтэй бүхнийг хадгалах, үргэлжлүүлэн хөгжүүлэх явдал мөн. Чухам тийм дэвшилтэй, үнэ цэнэтэй зүйл бол ахмад үеийн даруу төлөв, шудрага, хүлээцтэй, тэвчээртэй, сэтгэлийн тэнхээтэй, хүнлэг энэрэнгүй, хөдөлмөрч зэрэг сайхан зан чанар мөн. Энэ бүхэнгүйгээр залуу үеийг хүмүүжүүлэх тухай сэтгэшгүй юм.

Манай орчин үеийн залуучуудыг нийгэм- сэтгэл зүйн, сэтгэл зүйн гэсэн хоёр бүлэг болгон авч үзэж болох юм. Нэгдэх хэсгийн онцлог нь:

-Залуучуудын нийгмийн шууд хүрээлэл залуужсан, хүн амын насны бүтцэнд залуучууд эзлэх хувийн жингээрээ давамгайлах болсон явдал юм. Энэ онцлог үйлдвэрлэлийн хамт олныхоос оюуны хамт олны дунд бүр их тод илэрч байна.

-Ахмад ба залуу үеийнхний хоорондын тухайлсан харилцаа аажмаар суларч байна. Энэ нь нэгдүгээрт, улс орны эдийн засаг, улс төрийн бүтцэд их өөрчлөлт н сургалтын систем давамгайлж байгаагаар нөхцөлдөж байна. Хоёрдугаарт, -Залуучуудын өдөр тутмын үйл ажиллагаанд тухайлсан ба олон нийтийн харилцаа ихэссэнээр гэр бүлийнхний хүрээндэх ахмад ба залуу үеийнхний хоорондын тухайлсан харилцаа суларч байна. Энэ онцлог хамт олон, найз нөхөд үе тэнгийнхэн халамжлагчид хүмүүжүүлэгчид, олон нийтийн харилцаа холбооны хэрэгсэлийн үүрэг өсөн нэмэгдэж гэр бүлийн хүмүүжлийн үүрэг өөрчлөгдөж буй зэргээр илэрч байна.

Өнөөгийн залуучуудад насны сэтгэл зүйн дараах онцлог зуршмал шинж байна. Үүнд: - Орчин үеийн залуучуудын хүүхэд ахуйн хамт олонч чанар ахмад үеийнхээс өөрөөр илэрч байна. Гэр бүлээс гадна ахмад ба үе тэнгийнхэнтэйгээ байнга харилцах явцад хүүхэд ахуй цагийн хамт олонч ёсны сэтгэл зүйг эзэмших шаардлагатай болж байна. Үүний хамтаар гол төлөв боловсрол, хүмүүжлээр хангалтгүй залуу хүмүүсийн дунд ажиглагддаг “хуурамч нөхөрлөл”өөс чин үнэнч нөхөрлөлийг ялгаж үзэх; өөрийгөө хянах хяналтыг хүчтэй болгох хэрэгцээ өсөн нэмэгдсээр байна.

Ахмад ба залуу үеийн тухайлсан харилцаагүйгээр өмнөх үеүдийн хуримтлуулсан амьдралын баялаг туршлагагүйгээр хувь хүн иргэнших боломжгүй. Залуучуудад ахмадуудын өдөр тутмын дэмжлэг туслалцаа шаардагддаг. Энэ нь нийгэм, нийгэм-сэтгэл зүй, түүний дотор насны сэтгэл зүйн онцлогоос логик ёсоор ургаж гардаг. Эерэг, сөрөг тал бүхий хүүхэд насны сэтгэл зүйн онцлог залуу хүмүүст зуршмал байдаг. Залуучуудын сургалт, хүмүүжлийг авч үзэхдээ ахмад ба залуу хүмүүсийн хоорондын тухайлсан харилцаанд анхаарлаа хандуулах нь чухал.

Учир нь энэ бол хувь хүнийг иргэншүүлэх үндсэн арга зам мөн. Тэр тусмаа хүн амын 60 гаруй хувийг /0-18/ хүртлэх насны хүүхэд эзэлж байгаа байгаа манай оронд ахмад ба залуу хүмүүсийн хоорондын тухайлсан харилцааны асуудал улам бүр ач холбогдолтой болж байна"

Сургалтын зорилго бол суралцагчдыг мэдлэг, чадвар, дадлагаар баяжуулах төдийгүй тэднийг бие хүний хувьд нь хөгжүүлэх төлөвшүүлэх явдал мөн. Энэ учир хуучин нэрээр ЗХУ-ын нэрт сурган хүмүүжүүлэгч В.А.Сухомлинский залуу үеийг “ёс суртахуун, оюун ухаан сэтгэц өв тэгш хөгжилтэй, өгөөмөр сэтгэл, оюуны эрмэлзлэл, тэмүүллийн нандин чанартай болгож хүмүүжүүлэх...” нь сурган хүмүүжүүлэгчдийн гол үүрэг мөн гэж заажээ.

Залуучуудад цар хүрээтэй мэдлэг боловсролын үр дүнд иргэний зөв хүмүүжил төлөвшиж хүмүүжихийн хэрээр чөлөөт байдалтай болдог. Чөлөөт байдал нь биеэ даасан байдлаар нь илэрдэг.

Чөлөөт байдалд хяналт чухал. Иймд чөлөөт байдал, хяналтын харьцааны диалектикийг авч үзье. Эдгээр нь нэгдэл ба зөрчлийг агуулсан хам үзэгдэл ажээ. Залуучуудад мэдлэг боловсрол, хүмүүжил, биеэ даасан байдлын үр дүн болсон чөлөөт байдал төлөвшиж “гүйцэх” явцад тэдний төрөл, төрөгсөд, садан хамаатан, ойр тойрны хүрээлэгчид, сурган хүмүүжүүлэгчдийн зүгээс тавих хяналт харьцангуй давамгайлж байх шаардлагатай. Ийм хяналт бол жинхэнэ агуулгаараа засаг захиргааны хяналт, захирах тушаах албадах явдал бус харин залуучуудад анхаарал халамж тавих, дэмжлэг тусламж үзүүлэх сургалт - хүмүүжлийн үйл ажиллагаа юм. Ингэхлээр оюутнуунууд чөлөөлт байдал эзэмших тутам гаднын бусдын хяналт /халамж/-аас харьцаас харьцангуй чөлөөтэй байх чадвар, хүсэл эрмэлзлэлтэй болдог. Үүний хэрээр тэд өөрөө өөрийгөө хянах чадвартай болдог. Хэрэв энэ бүхнийг харгалзан үзэхгүй бол нэг талаас тухайн бие хүн /хөвгүүд, охид/-ийг бусдаас хараат бус чөлөөтэй байх гэсэн хүсэл эрмэлзлэл нөгөө талаас түүнийг бөөцийлөх гэсэн байнга оролдлого өөр хоорондоо зөрчилдөж эхэлдэг байна. Ийм зөрчил гаргахгүй байх гарсан ч түүнийг зөв зохистой шийдвэрлэх нь СХ-ийн нийгмийн нэг чухал үүрэг мөн.

Оюутнууд чөлөөт байдлыг эзэмших явцдаа болон түүний үр дүнд гэр бүлийн гишүүд найз нөхөд нийгмийн бусад гишүүдээс хөндийрч тусгаарлагдах бус харин ч болж нийгмийн харилцаанд илүү идэвхитэй татагдан оролцож чаддаг болох ёстой. Ингэхлээр оюутанд чөлөөт байдал эзэмшүүлэх нь соёлтой иргэн болгож төлөвшүүлэх улмаар нийгмийн нэгдэл залуу ба ахмад үеийн залгамж холбоог бэхжүүлэх нэг арга мөн.

Сурч хүмүүжигчийн зүгээс ч СХ-ийн зүгээс ч сургалт хүмүүжлийн сэтгэл зүйн зүй тогтлыг судалж мэдэх нь амжилт гаргах чухал нөхцөл мөн. Ямар ч тохиолдолд сургалт хүмүүжил нь тодорхой субъект /багш, шавь/-ын үйл ажиллагааны нэгдмэл онцгой төрөл болж илэрдэг. Энэ нь бүхэлдээ багш, шавийн хамтын ажиллагаа юм. Үүгээр: нэгдүгээрт, соёлын өнгөрсөн ба одоо, одоо ба ирээдүйн холбоо; хоёрдугаарт, багш нарын залуу, дунд ахимаг буюу ахмад үеийн хоорондын; гуравдугаарт, багш шавийн хоорондын залгамж холбоо, уламжлагдах ёс илэрч хангагдаж байдаг байна. Энэ нь уг чанартаа Оюутнуудад улс төрийн соёл төлөвшүүлэхэд сх-ийн гүйцэтгэж байдаг нийгмийн үүргийн илрэл юм.

СХС-ний хөдөлмөр ямар онцлог агуулж байна вэ? Багшлана гэдэг нь нэгдүгээрт, багш өөрөө эрдэм сурах, бусдыг эрдэмд сургах хоёрдмол үйл ажиллагаа юм. Аль ч хүний эрдэм сурах нь дэс дараалал үе шатуудтай, үе шат бүр нь харьцангуй тасалдал, тоо чанарын хэмжээс, үзүүлэлт, үнэлэлттэй байна.

Эрдмийг бусдаар заалгаж сурах; өөрөө биеэ дааж сурах хоёр арга зам байна. Хоёр дахь нь илүү үр ашигтай. Сургалтанд нэг дэх арга давамгайлж, оюутны биеэ дааж дайчилж өөрөө сурах авъяас сонирхол хүчин чармайлтыг гүйцэд өрнүүлж чадалгүй явж ирсэн нь сургалтын нэг үндсэн дутагдал юм. Төрөл бүрийн хичээлийн багш нар ямагт өөрөө сурахгүйгээр суралцагчдыг амжилттай сургаж чадахгүй. “багшийн эрдмээс шавийн эрдэм” шалтгаална гэж сургаж ирсэн нь үүнтэй

холбоотой билээ. СХС оюутанд хичээл зааж сургахын зэрэгцээгээр тэднийг өөрөө сурдаг арга чадвар дадлагатай болгохыг эрхэмлэх нь чухал гэсэн дүгнэлт урган гарч байна.

Хоёрдугаарт, аливаа хичээл оюутнуудад тухайн шинжлэх ухааны үсэг, тэмдэг томъёо, тодорхойлолт, аксиом, теором, категори, хууль баримтлал зэргийг зааж мэдүүлэхээр эхэлж үргэлжлэн гүнзгийрдэг нь мэдээж. Энэ бүхэн нь чухамдаа учрыг мэдүүлэх, нүдлүүлэх, тогтоолгон цээжлүүлэх, тогтоолгох, эргэж сануулах, ургуулан бодуулах тэдгээрийг зөв хэлүүлэх, бичүүлэх зэрэг олон талтай үйлдэл буюу үйл ажиллагааны амьд нэгдэл байдаг. Сурагч, оюутнууд заалгаж байгаа хичээлийнхээ утга учрыг л мэдвэл түүнийг амжилттай эзэмшиж чаддаг. Шинжлэх ухааны утга учрыг мэдэхийн тулд түүнийг мэддэг аргыг юуны өмнө эзэмшиж чадвал сая амжилтанд хүрч чадна. Иймээс багшийн хөдөлмөр суралцагчдад бэлэн мэдлэг дамжуулж өгөх бус тэрхүү мэдлэгийг өөрсдөө олж мэдэх аргыг эзэмшүүлэхэд чиглэх шаардлагатай. Эндээс төрөл бүрийн хичээлийн багш нар хөвгүүд, охидод ой ухааны хөгжил; ярианы болон бичгийн өндөр боловсрол, соёл төлөвшүүлэгч байх ёстой гэсэн дүгнэлт гарч байна.

Гуравдугаарт, хүнд эрдэм сургана, эрдэм сурах арга эзэмшүүлнэ гэдэг нь юуны урд түүгээр хөдөлмөр хийлгэнэ гэсэн хэрэг мөн. Эрдэм сургах, сурах ажил нь маш эмзэг, нарийн төвөгт чимхлүүр ажил юм. Энэ ажил анхнаасаа буруу ташаа, алдаа эндэгдэлтэй эхэлж явдаа саадтай тасалдал, гажуудалд орвол ололт амжилтаас гарз хохиролд хүргэдэг тал бий. Аливаа ажил, ухамсар, хүмүүжилтэй салшгүй холбоотойн адил сургах, сурах ажил нь хүмүүжил тулгуурладаг, хүмүүжлийн илрэл, үзүүлэлт байдаг. Үүгээр багшийн нэгдэл нөхцөлддөг. Эрхэлдэг ажил нь ийм болохоор багш бүхэн сурган хүмүүжүүлэгч мөн байх нь зүйн хэрэг юм. Сурган хүмүүжүүлэх гэдэг нь маш гүнзгий ойлголт юм. Монголчууд эрт дээр үеэс үр хүүхдээ сургаж хүмүүжүүлэхдээ ажилч хичээнгүй, үнэнч шударга, даруу төлөв хүн болгохыг эрхэмлэдэг байжээ. Ийм утга санаагаар “хүн болох нь багаасаа, хүлэг болох нь унаганаасаа” гэсэн зүйр цэцэн сургаалыг үг буй болж уламжлагдаж иржээ.

Одоогийн нөхцөлд хүн төрөлхтөний хувьд ч хөгжлийн өөр өөр түвшинд оршиж буй улс он тус бүрийн тухайд ч сурган хүмүүжүүлэх ажил улс төрийн ухамсар соёлтой салшгүй холбоотой болжээ. Бүх төрлийн мэргэжлийн багш нар улс төрийн өндөр соёлгүйгээр залуу үеийг сурган хүмүүжүүлэх үүргээ амжилттай биелүүлэх бололцоогүй болсон байна.

Аливаа хүн сурч ажилладаг, ажиллаж байж сурдаг. Энэ бол нэг талаар хүний мэдлэг, оюун ухааны өсөлт хөгжилийн нөгөө талаар ойлгож мэдэх, сэтгэх бодох, хүч гаргах ажлын буюу оюуны болон биений хөдөлмөрийн диалектик нэгдлийн илрэл юм. Хүний хөдөлмөрийн энэ онцлог сурагчдын үйл ажиллагаанд бүр ч их холбогдолтой. Иймээс багшийн хөдөлмөр шавийг заалгаж буй хичээлээ хийсвэр хэлбэрээр ойлгож мэдэх, мэдсэнээ биет байдлаар илэрхийлэх буюу хийж гүйцэтгэх /даалгавар хийх, дасгал бодох, зохион бичих, гэр орны хоол унд, угаалга, цэвэрлэгээ хийх, оёж шидэх, хувцас хунараа цэвэр ариг гамтай өмсөж эдлэх, эрүүл ахуйн шаардлага хангах/-д сургах, хүмүүжүүлэхэд зориулагдаж байдаг нь ойлгомжтой. Ингэхлээр сургах, хүмүүжүүлэх үүргийн үзэгдлийг зөрчвөл багшийн хөдөлмөрийн агуулга, ач холбогдол алдагдахад хүргэдэг.

Багшийн хөдөлмөрийн шинжлэх ухааны /эрдэм сургах/, нийгмийн /хүмүүжүүлэх ба биеэр хийх дадлага туршлага, хэвшил зуршилтай болгох/ үүрэг ба ач холбогдол зөвхөн хичээл зааж буй цаг хугацаагаар хэмжигдэх буюу хязгаарлагдах ёсгүй. “Жинхэнэ” багш заадаг хичээлийнхээ талаар сурагч, оюутнаа хараа, анхаарлаасаа хэзээ ч гаргадаггүй; хичээлийн бус бололцоотой цагт тэдэнтэйгээ уйгагүй ажиллаж улмаар тэднээр өөрийгөө хүндэтгүүлэн хүрээлүүлж, хичээлдээ сургаж, түүгээрээ дамжуулан тэднийг хүмүүжүүлдэг. Ийм багшийн хувийн үлгэр жишээний хүмүүжүүлэх ач холбогдол үнэхээр их байдаг.

Дөрөвдүгээрт, суралцагчдад тодорхой шинжлэх ухааны тодорхой шатны мэдлэг эзэмшүүлэх явцад болон түүний үр дүнд тэднийг зөв иргэншүүлж, төлөвшүүлэх нь багшийн хөдөлмөрийн чухал

зорилт мөн. Иргэншил маш өргөн утга агуулгатай. Хүн төрөлхтний аж төрөх онол суртахууны дагуу нийгмийн байгуулал; төр засгийн тогтолцоо, өөрчлөлт хөгжилтийн нөхцөлд зохицон нийцэж; нэгэнт тогтсон хууль зүй, ёс суртахууны хэм хэмжээнд нийцүүлэн эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх өөрөөр хэлбэл сурах хөдөлмөрлөх, аж төрөх, нийгэм – улс төрийн үйл ажиллагаанд оролцох мэдлэг, ухамсар, хүмүүжил, арга чадвар, идэвхи зэргийн цогцыг хүний иргэншил гэж үзэж болох юм. Иргэншлийг өргөн ба явцуу, зөв ба буруу, идэвхитэй ба идэвхигүй гэх мэтээр олон янзын хүрээ ба төвшинд ангилан үзэж болох бөгөөд энд тэр бүхнийг хөндөх шаардлагагүй гэж үзлээ.

СХС-дийн хөдөлмөрийн агуулга ач холбогдол, онцлог нь багшид мэргэжилдээ бүрэн эзэн болж түүнийгээ байнга баяжуулан гүнзгийрүүлж, мэдлэгээ хүнд зааж сургах, хүнийг зөв хүмүүжүүлэх арга ухааныг сайтар эзэмшсэн, хувийн өндөр үлгэр дууриалалтай байх шаардлагыг нөхцөлдүүлдэг.

СХС нийгмийн хуучирсан сэтгэл зүй, ангичилагдсан, өрөөсгөл үзэл суртлаас чөлөөлөгдөхдөө үеэ өнгөрөөснийг диалектикээр халах; дэвшилттэй үнэ цэнэтэйгий нь уламжлан авч бэхжүүлэн хөгжүүлэхийн чухлыг тэмдэглэж байгаа юм. Сургалтын систем дэх залгамж холбоо уламжлал ч СХС –ийн хөгжил төлөвшилд чухал ач холбогдолтой.

СХС бүтээлч хөдөлмөрөөс ирээдүйн хувь заяа, залуу үеийнхний чанар чансаа, бүтээл туурвил олон талаар хамаарч байна, хамаарах ч ёстой. Ийм учраас хуучин догматик сэтгэлгээ, хуучирсан мэдлэг, арга барилаасаа түргэн ангижирч, шинэ мэдлэг, шинэхэн арга барил эзэмшиж, өрсөлдөж ажиллах нь СХС зорилт болжээ. Үүнтэй холбогдон СХС-ний дунд нийгмийн шалгарал болох нь зайлшгүй. Өөрийгөө өөрийнхөө сэтгэлгээ, мэдлэг боловсрол, арга барилаа үнэхээр түргэн зоригтой шинэчилж цагийн аяс нөхцөл, шаардлагад нийцэж, ажиллаж чадах багш нар цаг үеийн зорилт, нийгмийн шалгаруулалтыг давж; Эс чадсан нь багш — сурган хүмүүжүүлэгчдийн эгнээнээс гээгдэж, багш хэмээх нэр алдраа алдаж, сурган хүмүүжүүлэх эрхэм хүндтэй албанаас халагдах нь зайлшгүй.

Залуу үеийг сурган хүмүүжүүлэх нь тухайн улс орны ирээдүйн хувь заяаны хэрэг дэвшлийн бодит баталгаа мөн. Багш нар сонирхлын дагуу сонгон авч эзэмшсэн боловсрол, мэргэжил, дадлага туршлагаараа улс орны одоо, ирээдүй үеийг боловсрол, мэргэжил ертөнцийг үзэх шинжлэх ухааны үзэл, цэвэр ариун ёс суртахуун, улс төрийн ухамсар соёлтой бол сурган хүмүүжүүлэх илүү бололцоотой юм.

Багш нарыг залуучуудыг сурган хүмүүжүүлэх нийгмийн гол хүч мөн гэж үздэгийн учир нь: нэгдүгээрт, хүүхэд залуучуудыг сурган хүмүүжүүлэх нь тэдний мэргэжлийн хөдөлмөр, амьжиргааны үндсэн арга юм. Хоёрдугаарт; энэ нь тэдний ёс суртахууны болон иргэний үүрэг мөн. Учир нь дур сонирхол, авьяасынхаа дагуу багшийн мэргэжил сонгон суралцан мэргэжсэн сурган хүмүүжүүлэгч суралцагчдад зүрх сэтгэлээ зориулан ажилладаг нь батлагдсан үнэн юм.

Гуравдугаарт, одоо улс орны ирээдүй хүүхэд, залуучуудаас олон талаар шууд хамааралтайг тодорхой хэмжээгээр илүү мэдэрч, ухамсарлаж байна.

Энэ бүхэн СХС нь залуу үеийг нийгмийн шинэ тогтолцоо, шинэ шаардлагад нийцүүлэн эрдэм номд сургах, иргэний эрхэм нандин зан чанартай болгон хүмүүжүүлэх аргаар тэдэнд улс төрийн ухамсар соёл төлөвшүүлэх гол хүч мөн гэсэн дүгнэлт гаргах үндэслэлтэйг харуулж байна. Чухам үүгээр багш сэхээтний нийгмийн үүрэг нөхцөлдөж байна.